



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 34

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдааны үеэр хурлын Төлөөлөгчдөөс гарсан санал, зарим сумаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Болд төмөр-Ерөө гол” ХХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК-ий үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, аймаг, сум орон нутагтай хамтран ажиллаж буй байдлыг шалган танилцаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Т.Сайнжаргал /Аймгийн ИТХ-ын Нийгмийн

бодлогын хорооны дарга/

Нарийн бичгийн дарга: А.Эрдэнэгэрэл /Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт,

хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн

дарга/

Гишүүд:

С.Раднаабазар /Аймгийн ИТХ-ын Байгаль орчин,

үйлдвэр хөдөө аж ахуйн бодлогын хорооны

дарга/

О.Буянаа /Аймгийн ИТХ-ын Эдийн засаг, төсвийн

бодлогын хорооны

дарга/

Ц.Эрдэнэчимэг /Аймгийн ИТХ-ын Нутгийн удирдлага

хууль хяналтын бодлогын хорооны

дарга/

Ж.Отгондалай /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч,

Жавхлант сумын Засаг дарга/

Ж.Отгонхүү /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын

дарга/

3.Түвшинтөгс /Аймгийн БОАЖГ-ын даргын үүргийг

түр орлон гүйцэтгэгч \

Б.Батнасан /Аймгийн ИТХ-ын ажлын албаны

ажилтан/


2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталж, шалган танилцсан ажлын дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, шийдвэрийн төслийг боловсруулан 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд даалгасугай.



ДАРГА

Г.БЯМБАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05-р дугаар сарын
01-ний өдрийн 34-дүгээр тогтоолын хавсралт



**“Болд төмөр-Ерөө гол” ХХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК-ий
үйл ажиллагааг шалган танилцах ажлын удирдамж**

2018.05.02

Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй “Болд төмөр-Ерөө гол” ХХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК-ий үйл ажиллагааг шалган танилцах ажлын хэсэг нь энэ удирдамжид заасан ажил үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагааны ТЭЗҮ, 2018 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө, Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт

- Газар, ус ашиглах гэрээний дүгнэлт;

- Байгаль орчны аудит хийлгэсэн эсэх;

- Уурхайн хаалтын төлөвлөгөө батлуулсан эсэх;

- Аймгийн ИТХ-ын 2007 оны 39 дүгээр тогтоолын хэрэгжилт;

- Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хэрэгжилт;

-Агаар, хөрс, орчны эрүүл ахуйн талаар холбогдох стандарт, журмын хэрэгжилт;

-Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх;

-Ажиллагсдын нийгмийн хангамжийн талаар авч буй арга хэмжээ. /ХАОАТ, НДШ/

- Аймаг, сум орон нутагт оруулж байгаа татвар, төлбөр, хураамжийн хэмжээ, хуулийн дагуу төлөгдөж байгаа эсэх;

-Орон нутгийн удирдлага, ард иргэдийн хамтын ажиллагаа, дэмжлэг туслалцаа, хамтран ажиллах гэрээтэй эсэх, тухайн орон нутагт ажлын шинэ байр бий болгосон байдал;

-Ерөө, Хүдэр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нартай уулзаж санал солилцох;

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ